

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2024 оны 08 дугаар сарын 12

Дугаар 106

Улаанбаатар хот

Хөдөлмөр зуслангийн дүрэм,  
үйлчилгээний үнийн тарифыг тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.4 дэх заалт, 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.12 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, дүүргийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 01/1900 тоот албан бичгийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит хорьдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Хүүхэд өсвөр үеийнхнийг соёлын орчинд өөрийн оролцоонд тулгуурласан хөтөлбөрөөр үндэсний өв уламжлал, соёл, ёс заншлаа дээдэлсэн, амьдрах арга ухаан, эерэг дадал эзэмшсэн, эх оронч үзэл бүхий иргэнийг нийгэмд бэлтгэх зорилгоор Баянзүрх дүүргийн хүүхдийн Хөдөлмөр зуслангийн дүрмийг нэгдүгээр, үйлчилгээний үнийн тарифыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Тогтоол батлагдсантай холбогдуулан дүрмийг улсын бүртгэлд бүртгүүлэхийг Хөдөлмөр зуслангийн захирал (С.Даваасамбуу)-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны даргад үүрэг болгосугай.

ДАРГА

А.БАЯР

Баянзүрх дүүргийн иргэдийн  
Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны  
08 дугаар сарын 12-ны өдрийн  
хорьдугаар хуралдааны 106  
тогтоолын нэгдүгээр хавсралт

## БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХАРЬЯА “ХӨДӨЛМӨР” ЗУСЛАНГИЙН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Баянзүрх дүүргийн Засаг даргын харьяа Хөдөлмөр зуслан (цаашид Хөдөлмөр зуслан гэх)-ийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, удирдлага, багш, ажилтан, амрагч хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн оролцоо, хамтын ажиллагаа, санхүү, төсөв тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Хөдөлмөр зуслан нь холбогдох хууль, стандартад заасны дагуу боловсролын зорилго болон сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, амрагч хүүхдийн хөгжил, төлөвшлийг дэмжсэн үйл ажиллагаа эрхлэх чиг үүрэг бүхий боловсролын сургалтын байгууллага, бие даасан хуулийн этгээд мөн.

1.3.Зуслан нь үйл ажиллагаандаа НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хүүхдийн зуслангийн үйл ажиллагааны ерөнхий шаардлага болон бусад хууль, тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн баталсан зуслангийн дүрмийг мөрдөнө.

Зуслангийн алсын хараа:

1.4.Эх оронч, үндэсний үзэл, хүмүүжил төлөвшил бүхий иргэнийг бэлтгэдэг тогтолцоо бүрдсэн, шилдэг шинэлэг хөтөлбөртэй зуслан болно.

Зуслангийн эрхэм зорилго:

1.5.Хүүхэд өсвөр үеийнхнийг соёлын орчинд өөрийн оролцоонд тулгуурласан хөтөлбөрөөр үндэсний өв уламжлал, соёл, ёс заншлаа дээдэлсэн, амьдрах арга ухаан, эерэг дадал эзэмшсэн, эх оронч үзэл бүхий иргэнийг нийгэмд бэлтгэхэд оршино.

### Хоёр. Зуслангийн үйл ажиллагааны, зарчим, үндсэн чиглэл

2.1.Зуслангийн дүрэм нь байгууллагын хэмжээнд хүчин төгөлдөр үйлчилж байгаа эрх зүйн баримт бичгийн үндэс болох бөгөөд зуслангийн дотоод харилцааг зохицуулах дүрэм, журам, заавар нь түүнд нийцсэн байна.

2.2.Зуслан нь хөгжүүлэх хөтөлбөрийн дагуу хүүхдэд амьдрах арга ухааныг хүүхдийн нас, бие, сэтгэхүйн онцлогт тохирсон үйл ажиллагаа, соёл хүмүүжлийн ажил, дугуйлан секцээр дамжуулан эзэмшүүлэх зорилготой сургалтын байгууллага байна.

2.3.Зуслан нь Баянзүрх дүүргийн засаг даргын харьяа ОНӨТҮГ /Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар/ байна.

2.4.Зуслан нь тогтоосон журмын дагуу тамга, тэмдэг, лого, туг, албан бичгийн хэвлэмэл хуудас, албан ёсны цахим хаяг, цахим хуудас ашиглана.

2.5.Зуслангийн албан ёсны хаяг Улаанбаатар хотоос зүүн тийш 80 км зайд буюу Төв аймаг Эрдэнэ сум 5-р баг Тамган өндөрт байрлана.

2.6.Зуслан нь Монгол улсын хууль тогтоомжийн холбогдох ерөнхий шаардлага, дүрэм, журмын хүрээнд гадаадын ижил төстэй байгууллагатай харилцаа тогтоож, хамтран ажиллаж болно.

2.7.Зуслан нь хамтарч ажиллах байгууллага, амрагч хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, олон нийтэд үйл ажиллагаагаа сурталчлах, мэдээлэл шуурхай хүргэх зорилгоор өөрийн албан ёсны цахим хаяг, нийгмийн сүлжээ ашиглаж болно.

2.8.Зуслан нь үйл ажиллагаандаа Боловсролын ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд зааснаас гадна дараах зарчмыг баримтална:

2.8.1.Амрагч хүүхдийн сурч хөгжих, хамгаалагдах, оролцох эрх болон хувь хүний онцлог, ялгаатай байдлыг хүндэтгэх;

2.8.2.Амрагч хүүхэд бүрд тэгш боломж олгосон чанартай үйлчилгээ үзүүлэх;

2.8.3.Ил тод, нээлттэй, жендерийн эрх тэгш байдал, шударга ёсыг эрхэмлэх;

2.8.4.Талуудын бүтээлч оролцоо, хамтын үйл ажиллагаанд суурилсан байх.

2.9.Зуслан нь Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд заасан үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхээс гадна энэ дүрмийн 1.2-т заасан чиг үүргийн хүрээнд дараах үйл ажиллагаа явуулна:

2.9.1.Суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрт заасан мэдлэг, чадварыг суралцагчдад эзэмшүүлэх сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах;

2.9.2.Харьяа газрын статистик хэмжил зүйн газраас үйл ажиллагаа эрхлэх тохирлын гэрчилгээний дагуу нэмэлт хөтөлбөрөөр амьдрах арга ухаанд сургах, нас, бие, сэтгэхүйн онцлогт тохирсон үйл ажиллагааг дамжуулан эерэг дадал, хүмүүжил, төлөвшил олгох сургалт явуулах;

2.9.3.Монголын түүх, хэл, соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлалаа дээдэлсэн, монгол иргэн төлөвшүүлэх ажлыг хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар зохион байгуулах;

2.9.4.Байгаль, эх дэлхийгээ хайрлах, хамгаалах, экологийн боловсрол олгох

2.9.5.Сурах, сургах үйл ажиллагааг амрагч хүүхэд бүрийн ялгаатай байдлыг хүндэтгэж, тэдний ахиц дэвшил, сурах үйлд тохирсон, суралцах тэгш боломж олгосон уян хатан арга хэлбэрээр зохион байгуулах;

2.9.6.Суралцахуйн түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүн бүхий хүртээмжтэй, аюулгүй, хамгаалагдсан, хамтран суралцах, хөгжих сургалтын орчин бүрдүүлэх;

2.9.7.Сургалтын хөтөлбөрөөр эзэмшвэл зохих мэдлэг, чадвар эзэмшилтийн түвшин, үнэлгээ, түүний үр дүн, амрагч хүүхэд бүрийн нийтлэг анхаарах асуудлын талаар эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдэд ил тод, нээлттэй, ойлгомжтой байдлаар мэдээлэх ажлыг тодорхой давтамжтай зохион байгуулах;

2.9.8.Зуслангийн байрны гадаад, дотоод орчинд хүүхдийн суралцахуйг дэмжих болон хүүхэд хамгаалал, хөгжлийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй, чанартай үзүүлэх;

2.9.9.Хүүхдийн эрхийн зөрчил, үе тэнгийн дээрэлхэл, дарамт, ялгаварлан гадуурхалт, гэмт хэрэг, хорт зуршил, эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, цахим орчны зохистой хэрэглээ, аюулгүй байдлаа хангах талаар амрагч хүүхдүүдийг соён гэгээрүүлэх, чадавхжуулах, оролцоог хангах олон талт арга хэмжээ зохион байгуулах;

2.9.10.Сургалтын технологийн шийдэл, амрагч хүүхэд бүрд тохирсон суралцахуйг дэмжих сургалтын платформ, ухаалаг төхөөрөмж, дижитал хэрэгслийг сургалт, үйл ажиллагаанд ашиглах техникийн болон сүлжээний дэд бүтцийн бэлэн байдлыг хангах;

2.9.11.Зуслангийн багш, амрагч хүүхдүүд сурч, хөгжих, хамтран ажиллах, мэдээлэл авах үйлийг дэмжихэд чиглэсэн номын сангийн үйлчилгээ үзүүлэх;

2.9.12.Амрагч хүүхдүүд, зуслангийн багш, ажилтны эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлж, зусланд суурилсан эрүүл мэндийн хяналт, тандалт болон нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх ажлыг (хамтрагч) мэргэжлийн байгууллага болон зуслангийн эмчтэй хамтран зохион байгуулах;

2.9.13.Амрагч хүүхдэд эрүүл, шим тэжээллэг, аюулгүй, хоол, хүнсээр үйлчлэх;

2.9.14.Амрагч хүүхдийг аюулгүй тээврийн үйлчилгээг зохион байгуулах;

2.9.15.Амрагч хүүхдэд шаардлагатай үед эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх;

2.9.16.Зуслангийн үйл ажиллагаанд талуудын оролцоотой өөрийн үнэлгээ хийж, үйлчилгээний чанар, үр дүнгээ сайжруулах;

2.9.17.Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хүүхдийн хөгжил, оролцоо, хамгааллын асуудлаар төр, хувийн хэвшил болон иргэний нийгмийн байгууллага, гадаад орон, олон улсын байгууллага, иргэнтэй холбогдох хууль тогтоомжид заасан хэм хэмжээний хүрээнд харилцах, хамтран ажиллах;

2.9.18.Зуслангийн үйл ажиллагаанд нутгийн захиргааны байгууллага болон олон нийтийн бодит оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх, холбогдох хуулиар олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг хүртээмжтэй түгээх.

2.9.19.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

### **Гурав.Удирдлага, зохион байгуулалтын бүтэц**

3.1.Зусланг дүүргийн Засаг даргын санал болгосноор дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг шийдвэрлэнэ.

3.2.Зуслангийн захирлыг дүүргийн Засаг дарга томилж, чөлөөлнө.

3.3.Захирлын тушаал нь хууль тогтоомжид нийцээгүй бол өөрөө эсхүл дүүргийн засаг дарга өөрчлөх буюу хүчингүй болгоно.

3.4.Захирал нь зуслангийн дүрэм болон гэрээгээр тогтоосон эрх хэмжээ, чиг үүргийнхээ хүрээнд зуслангийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.

3.5.Зуслангийн бүтэц, орон тооны дээд хязгаар, цалингийн санг захирлын саналыг харгалзан дүүргийн Засаг дарга баталж тогтооно.

3.6.Зуслангийн удирдлага нь өөрийн удирдлага, гүйцэтгэх удирдлага, мэргэжил, арга зүйн удирдлагаас тус тус бүрдэнэ.

3.7.Зуслангийн өөрийн удирдлага:

3.7.1.Зуслан нь зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх)-тэй байж болно. Зөвлөлийн гишүүд нь орон тооны бус байна.

3.7.2.Зөвлөл нь Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа. Ерөнхий шаардлага MNS 5633:2023 хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.7.3.Зөвлөл нь өөрийн үйл ажиллагааны дүрэм болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан “Зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам”-ыг баримтлан ажиллана.

3.8.Гүйцэтгэх удирдлага:

3.8.1.Хүүхдийн зуслангийн ерөнхий шаардлага MNS 5633:2023 6.1.5 заасны дагуу гүйцэтгэх удирдлага нь зуслангийн захирал (цаашид “захирал” гэх) байх бөгөөд захирал нь зуслангийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.

3.8.2.Захирал нь хууль тогтоомж, зуслангийн дүрэм, албан тушаалын тодорхойлолт, үүсгэн байгуулагч (томилох эрх бүхий этгээдтэй байгуулсан гэрээний дагуу) зуслангийн удирдлагыг хэрэгжүүлнэ.

3.8.3.Захирал нь Хүүхдийн зуслангийн ерөнхий шаардлага MNS 5633:2023 заасан нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.8.3.1.Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэн эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргах;

3.8.3.2.Захирал нь батлагдсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан газрын ажилтан, албан хаагчдыг ажилд томилох, хөдөлмөрийн гэрээ байгуулах, хууль тогтоомжийн хүрээнд ажлаас чөлөөлөх шаардлагатай тохиолдолд тодорхой хугацаагаар гэрээний үндсэн дээр мэргэжлийн хүн ажиллуулах;

3.8.3.3.Зуслангийн үйл ажиллагаа, орчныг сайжруулахад дотоодын хөрөнгө оруулалт болон олон улсын байгууллага, хандивлагч орнуудын зээл тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн үндэслэл, судалгаа гаргах, төсөл хэрэгжүүлэхэд давуу эрхтэйгээр оролцох;

3.8.3.4.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах;

3.8.3.5.Зусланг хариуцах асуудлаар холбогдох байгууллагатай бие даан харилцах, гэрээ байгуулах, хэлцэл хийхдээ засаг дарга, эсхүл тамгын газрын даргатай зөвшилцөнө;

3.8.3.6.Хамтын оролцоо, түншлэл, хяналт - үнэлгээ, дүн шинжилгээнд суурилсан менежмент, засаглалыг бэхжүүлэх, зуслан хөгжүүлэх дунд, богино хугацааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах;

3.8.3.7.Зуслангийн хэмжээнд мөрдөх сургалт, үйл ажиллагаа, хүүхэд хамгаалал, ёс зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой болон хөдөлмөрийн дотоод дүрэм, журмыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, мөрдүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

3.8.3.8.Зуслангийн дүрэм болон Хүүхдийн зуслангийн ерөнхий шаардлага MNS 5633:2023 заасан дүрэм, журам боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулахад багш, ажилтан, албан хаагч, амрагч хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч бүрийн оролцоог тэгш ханган тэднээс санал авч хэлэлцэж батална.

3.8.3.9.Багш, ажилтан, албан хаагч, амрагч хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх шийдвэр гаргахын өмнө тэдний саналыг заавал авч, багш нарын зөвлөлөөр хэлэлцэх, баталгаажсан шийдвэрийг мэдээлэх;

3.8.3.10.Зуслангийн хүний нөөц, барилга байгууламж, харилцаа холбоо, сүлжээ, цахим үйлчилгээ, тоног төхөөрөмж, цэвэрлэгээ үйлчилгээ болон харуул хамгаалалт, мэдээллийн аюулгүй байдлыг хангах;

3.8.3.11.Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдалд тавих дотоод хяналтыг зохион байгуулж, үр дүнг хариуцах;

3.8.3.12.Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах;

3.8.3.13.Дүүргийн Засаг даргаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэх;

3.9.Мэргэжил, арга зүйн удирдлага:

3.9.1.Зуслан нь мэргэжил, арга зүйн хамтын удирдлагыг хэрэгжүүлэх багш нарын зөвлөл, мэргэжлийн багш нарын бүлэгтэй байна.

3.9.2.Сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, хүүхдийн хөгжлийг дэмжих болон XXI зууны иргэний эзэмших ур чадварыг хөгжүүлэхэд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх арга замаа хамтран эрэлхийлэх, харилцан туршлага солилцох,

хамтын шийдэлд хүрэх замаар хамтран хөгжих, мэргэжлийн ур чадварыг тасралтгүй сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулна.

3.10.Зуслан нь сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах, шийдвэр гаргахад талуудын оролцоог хангах, амрагч хүүхдийн мөрдөх ёс суртахууны хэм хэмжээ тогтоох, багш, ажилтан, албан хаагч, амрагч хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон олон нийтээс санал, гомдол, мэдээлэл хүлээн авах, хянан шийдвэрлэх, хариу өгөх, цахим орчны зохистой хэрэглээг зохицуулах зэрэгтэй холбоотой дүрэм, журмыг баталж мөрдөнө.

3.11.Багшийн хөгжлийн өрөө, амрагч хүүхдүүдэд зөвлөгөө өгөх, дэмжин туслах нэгж, багш, ажилтны ёс зүйн асуудал хариуцсан дэд хороо, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөл, дотоод - хяналт, хүүхэд хамгааллын баг тус ажиллана.

3.12.Хөдөлмөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйл, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 18.8-д заасны дагуу багш, ажилтан, амрагч хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах, зуслангийн хөгжлийг дэмжих, хамтран ажиллах зорилго бүхий сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдсэн зөвлөл байж болно.

3.13.Энэ дүрмийн 3.7-д заасан багш, ажилтан, албан хаагч, амрагч хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн төлөөллийн зөвлөл нь зуслангийн бодлого, үйл ажиллагааг төлөөлөх хуулийн этгээд болохгүй.

### **Дөрөв. Багш, ажилтан**

4.1.Зуслангийн багш, ажилтан, албан хаагч үндэс угсаа, хэл, нас, хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, эдийн засаг, гэр бүлийн байдал зэрэг ямар нэгэн ялгаварлан гадуурхалтаас ангид байна.

4.2.Удирдлага, багш, ажилтан, албан хаагч нь Хөдөлмөрийн тухай болон бусад холбогдох хууль тогтоомж, ажил мэргэжлийн стандарт, албан тушаалын тодорхойлолтод заасан ажил үүргийг эрх бүхий этгээдтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр гүйцэтгэнэ.

4.3.Удирдлага, багш, ажилтан, албан хаагч нь Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Хүүхдийн зуслангийн ерөнхий шаардлага MNS 5633:2023 заасан ажил үүргийг хэрэгжүүлж, холбогдох хуульд заасан нийгмийн баталгаагаар хангагдана.

4.4.Удирдлага, багш, ажилтан, албан хаагч нь багаар хамтран ажиллах, бүтээлч үйл ажиллагаа, эв нэгдэл, эвсэг харилцаа, хүнлэг чанар, ёс суртахууны үнэт зүйлсийг дээдэлж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга ёсыг эрхэмлэн ажиллана.

4.5.Удирдлага, багш, ажилтан, албан хаагч нь хууль тогтоомж, сургуулийн дүрэм, ёс зүйн дүрэм болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад дүрэм, журмыг мөрдөнө.

4.6.Зуслангийн захирал, арга зүйч, нийгмийн ажилтан болон бусад багш, ажилтан, албан хаагч нь багшийн хувийн болон ажил хэргийн нэр хүндийг эрхэмлэн дээдлэх, худал мэдээлэл, гүтгэлэг, доромжлолоос сэргийлж ажиллана.

4.7.Удирдлага, багш, ажилтан, албан хаагчийн эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг зуслангийн дотоод журам, хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн гэрээгээр нарийвчлан тодорхойлно.

## **Тав. Амрагч хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч**

5.1. Амрагч хүүхэд нь Хүүхдийн зуслангийн ерөнхий шаардлага MNS 5633:2023 заасан эрх эдэлж, үүргийг хэрэгжүүлж, зуслангийн дүрэмд заасан хэм хэмжээг мөрдөнө.

5.2. Амрагч хүүхэд нь ёс зүйн дүрмийн хэм хэмжээг чанд сахина.

5.3. Хүүхдийн зуслангийн ерөнхий шаардлага MNS 5633:2023, зуслангийн дүрэм, журмыг зөрчсөн нь тогтоогдсон амрагч хүүхдийг эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч зуслангийн удирдлагатай байгуулсан гэрээг үндэслэн сануулах эсвэл гэрээг цуцлах, гэрт нь буцаах хүртэл арга хэмжээ авна.

5.4. Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь Боловсролын ерөнхий хуулийн 40 дүгээр зүйл, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 10 дугаар зүйл болон Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн тухай хуульд заасан үүргийг тус тус хэрэгжүүлнэ.

5.5. Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч цахим хэрэгсэл, сүлжээний зөв зохистой хэрэглээний талаар үлгэрлэх, хяналт тавих, хүүхдийнхээ сонирхол хэрэгцээнд нийцсэн хөгжлийн үйлчилгээнд хамруулах, тэдний нас, бие, сэтгэхүйн хөгжлийн онцлог, хүсэл сонирхол, зан төлөв, сурлага, эрүүл мэндийн талаар багш, холбогдох ажилтантай мэдээлэл солилцож хамтран ажиллана.

5.6. Амрагч хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь сургууль, багш, ажилтны нэр хүндэд сөргөөр нөлөөлөх худал мэдээлэл түгээхгүй байна.

5.7. Амрагч хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийн зуслангийн ерөнхий шаардлага MNS 5633:2023 болон холбогдох бусад хуульд заасан эрх зөрчигдсөн гэж үзвэл зуслангийн захиралд гомдол гаргаж болно.

5.8. Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн болон амрагч хүүхдийн зөвлөл нь өөрийн үйл ажиллагааны дүрмээ баталж мөрдөнө. Дүрэм нь Хүүхдийн зуслангийн ерөнхий шаардлага MNS 5633:2023, зуслангийн дүрэм, журам болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

5.9. Амрагч хүүхдийн зөвлөл нь зуслангийн орчинд амрагч хүүхдийн мөрдөх ёс суртахууны хэм хэмжээ тогтоохтой холбоотой дүрэм, журам боловсруулахад оролцох, батлагдсан шийдвэрийг бүх амрагч хүүхдэд таниулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүргийг хүлээж, хүүхдийн эрх, хөгжил, хамгаалал, оролцоог дэмжсэн үйл ажиллагаа явуулах, амрагч хүүхдийн санал бодлыг зуслангийн захиралд уламжлах зэрэг асуудлаар нийгмийн ажилтан, арга зүйч болон багш, ажилтан, албан хаагчтай хамтран ажиллана.

5.10. Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвлөл нь Хүүхдийн зуслангийн ерөнхий шаардлага MNS 5633:2023 хангах, хэрэгжүүлэх, хүүхдийн хөгжил, төлөвшил, сурах үйлийг дэмжих, тэдний нийгэм - сэтгэл зүй, аюулгүй байдал, хамгаалалтай холбоотой асуудлаар арга зүйч, нийгмийн ажилтан болон мэргэжлийн бүлэгтэй хамтран эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх, хамтарч ажиллах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

5.11. Зуслангийн удирдлага нь энэ дүрмийн 5.10-т заасан зөвлөлийн үйл ажиллагааны бие даасан байдалд хөндлөнгөөс нөлөөлөхгүй.

5.12. Тус дүрмээр амрагч хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зохицуулагдаагүй эрх, үүрэг, хариуцлагыг зуслангийн дотоод журам, дэг зэргээр зохицуулж болно.

## **Зургаа. Элсэлт**

6.1.Хүүхдийн зуслангийн ерөнхий шаардлага MNS 5633:2023 норм нормативыг баримтлан гэр, өрөөний дүүргэлтийг зохион байгуулах ажлыг зуслангийн захирал хариуцна.

6.2.Гэр, өрөөний дүүргэлт хүүхдийн зуслангийн ерөнхий шаардлага MNS 5633:2023 норм нормативыг хангаж зохион байгуулах журмыг зуслангийн дотоод журамд тусгаж дагаж мөрдөнө.

6.3.Амрагч хүүхдийн норм, нормативыг хангаж зохион байгуулахдаа нийгмийн хариуцлагын хүрээнд зуслан болон хамтарч ажилладаг байгууллага, төрийн албан хаагчийн хүүхэд, тус дүүргийг төлөөлөн сурлага, урлаг, спорт, нийгмийн идэвх оролцоо /хүмүүнлэг, сайн дурын, олон нийтийн арга хэмжээний оролцоо, шинэ санал санаачилга/, зорилтод бүлгийн, нэг айлын хоёр хүүхэд, ихэр хүүхэд, анги хамт олноороо явж байгаа хүүхдүүдэд хөнгөлөлттэй болон үнэгүй амрах хувь, хүүхдийн тоо хэмжээг зуслангийн дотоод журамд тусгаж дагаж мөрдөнө.

## **Долоо. Санхүү, төсөв**

7.1.Зуслангийн санхүү, төсөвтэй холбоотой өдөр тутмын үйл ажиллагаанд зарцуулагдах зардал, тооцоог захирал удирдана.

7.2.Зуслангийн орлого нь дараах санхүүгийн эх үүсвэрээс бүрдэнэ.

7.2.1.Орон нутгийн төсвийн санхүүжилт;

7.2.2.Үйл ажиллагаанаас олсон орлого;

7.2.3.Хандив, тусламж;

7.2.4.Хууль тогтоомжоор зөвшөөрсөн бусад эх үүсвэр.

7.4.Санхүү, төсвийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллана.

7.5.Зуслангийн батлагдсан төсөв, түүний гүйцэтгэл, зуслангийн орлого, зарлага, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг холбогдох хуульд заасан хугацаанд зуслангийн цахим хуудаст байршуулна.

7.6.Зуслангийн ээлжийн үнэ тарифыг Баянзүрх дүүргийн иргэдийн хурал батална. Баталсан үнэ тарифыг бараа бүтээгдэхүүний үнэ, өсөлтөд уялдуулан зуслангийн захиргааны зөвлөл жил бүр шинэчлэн баталж болно.



Баянзүрх дүүргийн иргэдийн  
Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны  
08 дугаар сарын 12-ны өдрийн  
хорьдугаар хуралдааны 106  
тогтоолын хоёрдугаар хавсралт

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ХАРЬЯА ХӨДӨЛМӨР ЗУСЛАНГИЙН  
7 ХОНОГИЙН ҮНИЙН ТАРИФ

| Д/д | Зуслангийн амрагч хүүхдийн төрөл | Үнийн тариф | Тайлбар           |
|-----|----------------------------------|-------------|-------------------|
| 1   | Амрагч хүүхэд                    | 350,000     | Үндсэн төлбөр     |
| 2   | Төрийн албан хаагчийн хүүхэд     | 210,000     | Хөнгөлөлт 40 хувь |